



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 1177

Арвайхээр сум

Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн  
гурван талт хороо байгуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талд үндэсний хорооны 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Салбар хороо болон аймаг, нийслэлийн хорооны дүрэм батлах тухай” 01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Аймгийн хорооны дарга: А.Ишдорж (аймгийн Засаг дарга)

Гишүүд : Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Т.Нарангарав (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Баярабат (аймгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга)

Д. Наранчимэг (аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйлдвэрчний хорооны дарга)

Д. Сосорбарам (Арвайхээр сумын Үйлдвэрчний хорооны дарга)

О. Гансүх (аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга)

Б. Батмөнх (аймгийн Ажил олгогч эздийн холбооны гишүүн)

Ш. Отгонжаргал (аймгийн Ажил олгогч эздийн холбооны гишүүн)

2. Аймгийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны ажлын албаны үүргийг гүйцэтгэн ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Нарангарав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0322  
D:My Doc. Zahiramj. Zasag darga